



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/395

Хэрлэн сум

Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу иргэн Гомбо Бямбацогт (РД:СЖ78070111)-ын эзэмшлийн Хэрлэн сум 4 дүгээр баг, Тариаланчид-Б 17-15 тоот хаягтай Гэр бүлийн зориулалттай 700м² газрыг иргэн Сүх-Очир Энхчимэг (РД:СЮ92082604)-т холбогдох бичиг баримтыг үндэслэн газар эзэмших эрхийг шилжүүлсүгэй.

2.Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан иргэдэд газар эзэмших эрхийн гэрчилгээг олгож, гэрээ байгуулан биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Б.Сүнгээ)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбоотойгоор Засаг даргын 2023 оны А/318 тоот захирамжийн дээрх иргэнд холбогдох заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ